



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар A/292

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.3, 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусlamж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Жирэмсэн үед үзүүлэх тусlamж, үйлчилгээ, хяналтын товлол", "Төрсний дараах үед үзүүлэх тусlamж, үйлчилгээ, хяналтын товлол"-ыг хоёрдугаар, "Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн эрсдэлийг илрүүлэх асуумж"-ыг гуравдугаар, "Жирэмсний бүлгийн сургалтын агуулга"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг мөрдэж ажиллахад нэн шаардлагатай оношлуур, урвалж, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжид шаардагдах хөрөнгийг жил бурийн төсөвтөө тусгаж санхүүжүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Журмыг хэрэгжүүлэхэд улсын хэмжээнд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Алтантуяа), Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Д.Мөнхцэцэг)-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал)-т даалгасугай.

5. В-Стрептококкын шинжилгээг хийхэд шаардлагатай санхүүжилтийг төсөвт тусгах, 2025 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан), өртгийн жинг тооцоолж эрүүл мэндийн даатгалд хамруулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны 318 дугаар тушаалыг хүчингүйд тооцоугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
08. сарын 14 өдрийн дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЖИРЭМСЭН, ТӨРӨХ, ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайн эрүүл мэндэд тулгарч буй эрсдэл, хүндрэлийг эрт илрүүлэх, тандах, сэргийлэх, эмчлэх, эсэн мэнд амаржуулах, нотолгоонд сууринсан цогц тусlamжийг хугацаа алдалгүй үзүүлэх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Уг журмыг жирэмсэн, төрөх, төрсний дараах үед тусlamж, үйлчилгээ үзүүлдэг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд дагаж мөрдөнө.

Хоёр. Тусlamж, үйлчилгээний үндсэн зарчим

- Нөхөн үржихүйн хэвийн физиологийн үйл ажиллагааг дэмжсэн тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.
- Эрх тэгш, хүртээмжтэй, хариуцлагатай тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.
- Үйлчлүүлэгч төвтэй, нотолгоонд сууринсан, чанартай, аюулгүй тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.
- Эмэгтэйн эрх ашиг, сонголт, сэтгэл санаа, сэтгэл зүй, соёл, зан заншлыг хүндэтгэн, нууцыг хадгална.
- Эмэгтэй, түүний хамтрагч, гэр бүлд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээллээр хангах, дэмжлэгт орчин бүрдүүлнэ.
- Яаралтай тусlamж шаардлагатай тохиолдолд жирэмсэн, төрөх, төрсний дараах тусlamжийг хамгийн ойр эрүүл мэндийн байгууллагад үзүүлнэ.
- Тусlamжийг багаар (эх барих, эмэгтэйчүүд, нярайн эмч, өрх, сумын эмч, эх баригч, сувилагч, бусад шаардлагатай мэргэжлийн эмч) үзүүлнэ.
- Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусlamж, үйлчилгээг эмнэлзүйн удирдамж, зааврыг баримтлан, эрүүл мэндийн байгууллагын тусlamж, үйлчилгээ үзүүлэх хүрээ, эмнэлгийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын дагуу үзүүлнэ.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт, эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг

3.1 Эрүүл мэндийн яам

- Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусlamж, үйлчилгээний эрх зүйн орчинг сайжруулах, журам, стандарт, эмнэлзүйн зааврыг боловсруулах, шинэчлэх, хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийнэ.
- Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусlamж, үйлчилгээний тоон ба чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх, нотолгоонд сууринсан дүгнэлт, зөвлөмжийг улирал бүр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.1.3 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусlamж, үйлчилгээнд шаардагдах санхүүгийн тооцоог шинэчлэх, төсвийг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулна.

3.2 Эрүүл мэндийн хөгжлийн төв

3.2.1 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусlamж, үйлчилгээний тоон ба чанарын үзүүлэлтийг цахим эрүүл мэндийн системд нэгтгэж, улсын хэмжээнд мэдээллийн санг үүсгэн, улирал бүр Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газарт тайлагнана.

3.2.2 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.3 Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

3.3.1 Эх барих, эмэгтэйчүүд, ураг, нярайн тусlamж, үйлчилгээг улсын хэмжээнд мэргэжлийн арга зүйгээр хангана.

3.3.2 Жирэмсэн, төрөх, төрсний дараах тусlamж, үйлчилгээний тандалт, судалгааг хийх, тоон ба чанарын үзүүлэлтийн мэдээллийг улирал бүр улсын хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, бодлого боловсруулахад нотолгоо баримтаар хангана.

3.3.3 Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусlamж, үйлчилгээний удирдамж, зааврын төслийг боловсруулна.

3.3.4 Жирэмсэн, төрөх, төрсний дараах болон ураг, нярайн тусlamж, үйлчилгээний чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж бэлтгэнэ.

3.3.5 Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг дараах оношийн дагуу хянаж, төрүүлнэ.

3.3.5.1 Зүрхний төрөлхийн болон олдмол гажигтай, зүрх, судасны эмгэгийн үйл ажиллагааны алдагдалтай;

3.3.5.2 Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийгдсэн;

3.3.5.3 Тодорхой байрлалтай хорт хавдартай;

3.3.5.4 Резус сөрөг бүлгийн цус мэдрэгшсэн тохиолдол;

3.3.5.5 Зуршмал дутуу тээлтийн үеийн хяналт, жирэмсний тээлтийн 32 долоо хоног ба түүнээс доош хугацаанд төрүүлэх бол;

3.3.5.6 Төрсний дараа нярайн мэс заслын мэргэжлийн тусlamж үзүүлэх шаардлагатай;

3.3.5.7 Нэг ихэстэй эсвэл ургийн эмгэгтэй ихэр жирэмсэн;

3.3.5.8 Гурав ба түүнээс дээш олон урагтай жирэмсэн;

3.3.6 Телемедицин, цахимаар зөвлөгөө өгөх, орон нутагт зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

3.3.7 Перинатологийн клиник нь улсын хэмжээнд эх, ургийн анагаах ухааны мэргэшсэн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөх, тандалт судалгаа хийж, хариу арга хэмжээ авна.

3.3.8 Тандалт судалгааны алба нь улсын хэмжээнд эхийн эндэгдлийн тохиолдлыг 24 цагийн дотор бүртгэж, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газарт мэдээлнэ.

3.4 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв

3.4.1 Жирэмсэн, төрсний дараах үед эрхтэн тогтолцооны хавсарсан эмгэгтэй эмэгтэйг лавлагаа төвийн үндсэн чиглэл, тусlamж, үйлчилгээ үзүүлэх хүрээний дагуу хүлээн авч, хамтран хянах, хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.

3.4.2 Жирэмсэн, төрсний дараах үед ноцтой хүндэрсэн эхэд эмч нарын хамтарсан үзлэг, зөвлөгөөнийг шуурхай хийж, оношилгоо, эмчилгээг цаг алдалгүй шийдвэрлэх, төрөлтийн асуудал шийдэгдсэн тохиолдолд лавлагаа төвийн үндсэн чиглэлийн дагуу шилжүүлэн авч, тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангана.

3.4.3 Хэвтүүлэн эмчлэх шаардлагатай жирэмсэн эмэгтэйн эрхтэн тогтолцооны хавсарсан эмгэгийг тээлтийн 28 долоо хоногийн доторх хугацаанд эмчилнэ.

3.4.4 Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв нь төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан бүтэц, үйл ажиллагааны стандартад заасны дагуу өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг хянаж, төрүүлнэ.

3.4.5 Халдварт өвчин судлалын үндэсний төв нь цочмог явцтай халдварт өвчинтэй жирэмсэн эмэгтэйг үндсэн оношийн дагуу оношлох, эмчлэх болон төрөх үеийн тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.

3.4.6 Жирэмсэн, төрөх, төрсний дараах тусlamж, үйлчилгээний тоон ба чанарын үзүүлэлтийн мэдээллийг улирал бүр Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанад мэдээлнэ.

3.5 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

3.5.1 Аймаг, нийслэлийн хэмжээнд жирэмсэн, төрөх, төрсний дараах эх, нярайд үзүүлэх тусlamж, үйлчилгээтэй холбоотой яаралтай асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэж, эрүүл мэндийн байгууллага хоорондын уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангана.

3.5.2 Аймаг, нийслэлийг эх барих, эмэгтэйчүүд, нярайн эмч, эх баригч, нярайн сувилагчаар хангах, тогтвортой суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5.3 Аймаг, нийслэлийн эх барих, эмэгтэйчүүд, нярайн эмч, эх баригч, бага эмч, нярайн сувилагч, сум, өрх, багийн эмч нарыг эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тусlamжийн чиглэлээр ажлын байрны сургалтад тасралтгүй хамруулна.

3.5.4 Жирэмсэн, төрөх, төрсний дараах эх, нярайн тусlamж, үйлчилгээнд шаардлагатай оношуур, урвалж, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр тасралтгүй хангана.

3.5.5 Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд /БНҮЭМ/, эсэн мэнд амаржихуйн чиглэлээр иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна.

3.5.6 Аймаг, нийслэлийн хэмжээнд жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд улирал тутамд хяналт, үнэлгээ хийж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.7 Жирэмсэн эмэгтэй бүрийг эрт хяналтад ороход дэмжлэгт орчин бүрдүүлэх, хяналт тавих, цахим бүртгэлтэй уялдуулан "Нэрийн хяналт"-ийг хэрэгжүүлнэ.

3.5.8 Харьяалах нутаг дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын жирэмсэн, төрөх, төрсний дараах тусlamж, үйлчилгээний тоон ба чанарын үзүүлэлтийн мэдээллийг цуглувалж улирал бүр Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанад мэдээлнэ.

3.6 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, эх барихын тусlamж, үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшлийн эмнэлэг

3.6.1 Харьяалах нутаг дэвсгэрт ажиллаж буй эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарт сум, хороог хариуцуулан уялдаа холбоог хангаж, эргэх холбоотой ажиллана.

- 3.6.2 Жирэмсэн, төрөх, төрсний дараах тусламж, үйлчилгээнд эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, зөвлөх эмч, тасгийн эрхлэгч, чанарын алба хяналт тавина.
- 3.6.3 Шатлалын дагуу жирэмсэн эмэгтэйд эх барих, эмэгтэйчүүдийн эмч үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалд шилжүүлнэ.
- 3.6.4 Төрөлжсөн мэргэшлийн эмч нь эх барих, эмэгтэйчүүдийн болон өрх, сум, тосгоны эмчийн илгээсэн жирэмсэн эмэгтэйг үзэж, хавсарсан эмгэгийг оношилж эмчилилнэ.
- 3.6.5 Өндөр эрсдэлтэй жирэмснийг тээлгэх эсэх асуудлыг эх барих, эмэгтэйчүүдийн болон төрөлжсөн мэргэшлийн эмч нар хамтарсан үзлэг хийж, хугацаа алдахгүй шийдэж, харьяаллын дагуу амаржих газар, төрөх тасагт эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 3.6.6 Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, хавсарсан эмгэгтэй тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмчтэй хамтран хянана.
- 3.6.7 Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйн хяналтын төлөвлөгөө, товлолыг эх барих, эмэгтэйчүүдийн эмч боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.6.8 Алслагдсан нутагт амьдарч байгаа эсхүл өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг төрөхөөс 07-14 хоногийн өмнө Аймгийн нэгдсэн эмнэлгийн эхийн амрах байранд амруулж төрүүлнэ.
- 3.6.9 Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг оношийн дагуу бүлэгт хувиарлан гэр бүл, хамтрагчийг оролцуулан бүлгийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулна.
- 3.6.10 Аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв нь жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд нөлөөлөх орчны хүчин зүйлийг тогтоох, эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.6.11 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед ноцтой хүндэрсэн тохиолдлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдээлэх, мөн харьяа дүүрэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн цахим системээр үйлчлүүлэгчийн мэдээллийг илгээж, хамтран хянах, эргэх холбоотой ажиллана.
- 3.6.12 Амьгүй эсхүл дутуу төрсөн эхчүүдийг харьяа дүүрэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн цахим системээр үйлчлүүлэгчийн мэдээллийг илгээж, урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээний төлөвлөгөөг гарган хамтран хэрэгжүүлнэ.
- 3.6.13 Жирэмсэн, төрөх, төрсний дараах тусламж, үйлчилгээний тоон ба чанарын үзүүлэлтийн мэдээллийг улирал бүр аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдээлнэ

3.7 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв

- 3.7.1 "Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа", "Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа"-ны стандартад заасны дагуу иргэдэд нөхөн үржихүй, жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 3.7.2 Харьяалах нутаг дэвсгэрийн нөхөн үржихүйн насны иргэдийн цахим бүртгэл судалгааг хийж, жил бурийн шилжилт хөдөлгөөнийг шинэчилнэ.
- 3.7.3 Үндсэн оршин суугаа хаягандаа байдаггүй жирэмсэн эмэгтэйн мэдээллийг түр оршин суугаа хаягийн дагуу эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн цахим системээр илгээж, шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах, тухайн эрүүл мэндийн байгууллагатай эргэх холбоотой ажиллана.

- 3.7.4 Харьяалах нутаг дэвсгэрийн өсвөр насны хүүхдийн бүртгэл судалгааг гаргаж, боловсролын байгууллагатай хамтран эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө өгнө.
- 3.7.5 Харьяалах нутаг дэвсгэрийн хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар түр алдалттай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл судалгааг гаргаж, төрийн ба төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтэнтэй хамтран эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө өгнө.
- 3.7.6 Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 3.7.7 Нөхөн үржихүйн насны иргэдийг, түүний хамтрагч, гэр бүлийн хамт эрт илрүүлэгт хамруулах, эрсдэлийг тогтоох, эмчлэн эрүүлжүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө өгнө.
- 3.7.8 Нөхөн үржихүйн насны иргэд, түүний хамтрагч, гэр бүлд жирэмслэхээс өмнөх тусламж, үйлчилгээг үзүүлж, нотолгоонд сууринсан эрүүл мэндийн зөвлөгөө өгнө.
- 3.7.9 Хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг товлолын дагуу хянах, тээлтийн 20, 32 долоо хоногтойд эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмчид үзүүлж, зөвлөгөө авах, эрүүл мэндийн цахим системээр мэдээллийг харилцан солилцно.
- 3.7.10 Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг илрүүлж, эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад шилжүүлэх, мэдээллийг эрүүл мэндийн цахим системээр харилцан солилцох, хяналтын төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлж эргэх холбоотой ажиллана.
- 3.7.11 Алслагдсан нутагт амьдарч байгаа эсхүл өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдтэй эргэх холбоо тогтоон, төрөх хугацаанаас 07-14 хоногийн өмнө БОЭТ, нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг/ амаржих газарт илгээнэ.
- 3.7.12 Эх, нярайг товлолын дагуу гэрээр эргэж хянах, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээг удирдамж, зааврын дагуу үзүүлж, эрүүл мэндийн цахим системд баримтжуулна.
- 3.7.13 Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед ноцтой хүндэрсэн болон амьгүй, дутуу төрсэн эхчүүдийг товлолын дагуу гэрээр эргэх, эх барих, эмэгтэйчүүдийн эмчтэй хамтран оношилгоо, эмчилгээний төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх, шаардлагатай бол дараагийн шатлалд шилжүүлнэ.
- 3.7.14 Жирэмсэн эмэгтэй бүрийг эрт хяналтад хамруулахад иргэд, нийгмийн ажилтан, төрийн бус байгууллага, олон нийт, сайн дурын идэвхтний дэмжлэгийг авч, хамтран ажиллана.
- 3.7.15 Жирэмсэн болон төрсэн эмэгтэйд эрүүл ахуй, хоол тэжээл, олон найрлагат бичил тэжээлийн зөвлөгөөг өгч, гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх дэмжлэгт орчинг бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хоол зүйчтэй хамтарч ажиллана.
- 3.7.16 Жирэмсэн эмэгтэй, түүний хамтрагч, гэр бүлийг оролцуулан бүлгийн сургалтыг 3-аас багагүй удаа цахим болон танхимаар эрүүл мэндийн байгууллагаас баталсан удирдамж, сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.
- 3.7.17 Жирэмсэн, төрөх, төрсний дараах тусламж, үйлчилгээний тоон ба чанарын үзүүлэлтийн мэдээллийг улирал бүр аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
сарын 01-өдрийн 10-ны
тушаалтын хоёрдугаар хавсралт

Хүснэгт 1. Жирэмсэн үед үзүүлэх тусламж үйлчилгээ, хяналтын товтол

Үзлэгийн дугаар, товтол	Тээлтийн хугацаа	Үзлэгийн зорилго	Асуумж	Үзлэг	Шинжилгээ	Сургалт, зөвлөгөө
Анхны Үзлэг (≤ 10 долоо хоногтойд) Үзлэгжэх хугацаа: 40	1. Жирэмсний хугацааг тодорхойлно 2. Одоогийн жирэмслэгэлтийн талаар 3. Өмнөх жирэмсэн, төрөлтийн талаарх мэдээлэл 4. Эрүүл мэндийн дурьдатгал 5. Нийэм, эдийн засгийн эрдээлт хүчин эйл 6. Ажлын нөхцөл боловсруулна 7. Ондөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйт илрүүлэх асуумж (Хавсралт 3) 8. Хүчирхийллийг илрүүлэх асуумж (Хавсралт 3) 9. Сурьеэ илрүүлэх асуумж (Хавсралт 3) 10. Гүнийн венийн бүлэгт	Асуумжийг гүйцэт, дэлгэрэнгүй авна. 1. Зовуурь 2. Одоогийн жирэмслэгэлтийн талаар 3. Өмнөх жирэмсэн, төрөлтийн талаарх мэдээлэл 4. Эрүүл мэндийн дурьдатгал 5. Нийэм, эдийн засгийн эрдээлт хүчин эйл 6. Ажлын нөхцөл боловсруулна 7. Ондөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйт илрүүлэх асуумж (Хавсралт 3) 8. Хүчирхийллийг илрүүлэх асуумж (Хавсралт 3) 9. Сурьеэ илрүүлэх асуумж (Хавсралт 3) 10. Гүнийн венийн бүлэгт	Ерөнхий биенний үзлэгийг хийнэ. 1. Ерөнхий биенний үзлэг 2. Амин үзүүлэлт 3. Биенний ондөр (Биенний жингийн индекс) 4. Амны хөндий, шудний үзлэг 5. Хөхний үзлэг 6. Толгыны үзлэг 7. Үтрээний үзлэг 8. Үтрээний наацын шинжилгээ 9. Шээсэнд илрүүлэх*** (12-16 доллоо хоногтойд) 10. Гренатал илрүүлэг*** (11-13+6 хоногтойд)	Заавал хийх шинжилгээ: 1. Цусны бүлэг 2. Резус бүлэг 3. Цусны шинжилгээ 4. Шээсний шинжилгээ 5. Элэгэний В, С вирус илрүүлэх 6. Тэмбүүг илрүүлэх (хурдчавчилсан аргаар зерэг гарсан үед онош баталгаажуулах) 7. ХДХВ-ийг илрүүлэх (хурдчавчилсан аргаар зерэг гарсан үед онош баталгаажуулах) 8. Утрасэний наацын шинжилгээ 9. Шээсэнд илрүүлэх*** (12-16 доллоо хоногтойд) 10. Гренатал илрүүлэг*** (11-13+6 хоногтойд)	Бүлгийн сургалт-1*** (Хавсралт 4) Зөвлөгөө: 1. Жирэмсний хяналтын холбогдол, физиологийн өөрчлөлт 2. Жирэмсэн үеийн хөрөнгөлтөөн мэндч, зохицтой хэрэглээ 3. Амны хөндийн эрүүл мэнд, хөндийн зорилт 4. Эмийн хэрэглээ 5. Жирэмсэн хоополт, амин, эрдсийн хэрэглээ (фолиин темрийн бэлдмэл гм) 6. Гренатал илрүүлэг, оношилгоо 7. Хорт зурслаас татгалзах, архи тамхины хор уршиг 8. Халдвараас сэргийлэх, гар 9. Жирэмсэн, төрөлтийн шинжилгээ - Биохимийн шинжилгээ - Бамбай булчирхайн дааврын шинжилгээ	Сургалт, зөвлөгөө: 1. Жирэмсний хийх шинжилгээ 2. Жирэмсэн, төрөлтийн шинжилгээ хууль

№1

<p>11. Манас таталтын урьдлын эрсдэлт хүчин зүйл</p> <p>Өндөр эрсдэлтэй жиремсэн: Төрөлжсөн мэргэжлийн Узлэгт хамруулах, эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад шилжүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Умайн хүзүүний эсийн шинжилгээ "TORCH" халдвартын илрүүлэх Элэгтийн илрүүлэх Манас таталтын урьдлыг илрүүлэх Пренатал оношилгоо - "TORCH" халдвартыг Элэгтийн Д вирус Манас таталтын цахим хөтөч ашиглах хяналтын төлөвлөө, товтолд 12. Булгийн сургалтад зайлшгүй хамрагдах тухай 	<p>10. Эх хүүдийн эрүүл мэндийн дэвтэр, жирэмсний хяналтын цахим хөтөч ашиглах хяналтын 11. Жирэмсний төлөвлөө, товтолд 12. Булгийн сургалтад зайлшгүй хамрагдах тухай</p>
<p>20 долоо хоног</p> <p>№2</p>	<p>1. Жирэмсний явц, ургийн ёсөлт хөгжлийг хянана</p> <p>2. Жирэмсний өндөр эрсдэлийг илрүүлнэ</p> <p>3. Ургийн анатомийн бүтэц, хүйн ихэс, байдлыг, шинжилгээ, эмгэгтийг илрүүлнэ</p> <p>*Эх эмэгтэйчүүдийн эмч Узлэг хийж, зөвлөгөөө өгнө</p>	<p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p> <p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p> <p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p> <p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p> <p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p>
<p>24 долоо хоног</p> <p>№3</p>	<p>1. Жирэмсний явц, ургийн ёсөлт хөгжлийг хянана</p> <p>2. Эрүүл мэндийн боловсрол олгох булгийн сургалтыг зохион байгуулна</p>	<p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p> <p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p> <p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p> <p>1. Ерөнхий биелйн узлаг 2. Амин Үзүүлэлт 3. Биелжин жин 4. Амины хөндий, шудний үзлэг</p>
		<p>Зөвлөгөө:</p> <ol style="list-style-type: none"> Жирэмсэн аюултай шинжүүд Жирэмсэн дасгал хөдөлгөөн Жирэмсэн үеийн ахуй эрүүл хувцаслалт, аяллаар явах) Жирэмсэн үед аялах /агаарын тэвэрээр зорчих, жолоо барих/ Бэлгийн замаар дамжих халдвартын талаар Сэтгэлзүйн зөвлөгөө <p>Булгийн сургалт-2*** (Хавсралт 4)</p> <p>Зөвлөгөө:</p> <ol style="list-style-type: none"> Жирэмсэн аюултай шинжүүд Цус багадалтын тухай Жирэмсний хожуу хордлогын тухай

	28 долоо хоног	<p>1. Жирэмсний явц, ургийн хөгжлийг хянанаа</p> <p>2. Жирэмсний өндөр эрдээллийг илрүүлнэ</p>	<p>1. Зовуурь Узлэг</p> <p>2. Өндөр эрдээлтэй жирэмсэн эмэгтэйг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p> <p>Өндөр эрдээлтэй жирэмсан: Төрөлжсөн мэргэжлийн Узлэгт хамрууллах, эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хянаныг шилжүүлнэ.</p>	<p>1. Ерөнхий биесийн Узлэг</p> <p>2. Амин үзүүлэлт</p> <p>3. Биесийн жин барихын гадуур Узлэг (Ургийн байрлал, янз, түрүүлсэн хэсгийг тодорхойлно)</p>	<p>1. Тэмбүүгийн давтана Чихрийн шижкингийн өндөр эрдээлтэй уед сахроны ачаалалтай сорил</p> <p>2. Чихрийн шижкингийн өндөр эрдээлтэй уед сахроны ачаалалтай сорил</p> <p>3. Хэт авиан шинжилгээ</p>	<p>1. Жирэмсэн аюултай шинжүүд Эхээс урагт дамжих халдварт /ХДХВ/ДОХ,</p> <p>Тэмбүү, гепатитын В вирус/</p> <p>3. Жирэмсний чихрийн шижкингийн тухай</p> <p>4. Эрхтэн тогтолцооны эмэгтэйн талаар</p>
				<p>1. Ерөнхий биесийн Узлэг</p> <p>2. Амин үзүүлэлт</p> <p>3. Биесийн жин барихын гадуур Узлэг</p>	<p>1. Цусны шинжилгээ Шээсний шинжилгээ</p> <p>2. Шинжилгээ Утрас, уマイн хувууний нийтон турхцийн шинжилгээ (МАЗОК)</p> <p>3. Утрас, уマイн хувууний нийтон турхцийн шинжилгээ (МАЗОК)</p> <p>4. Хэт авиан шинжилгээ</p>	<p>Бүлгийн сургалт-3*** (Хавсралт 4)</p> <p>Зөвлөгөө:</p> <p>1. Жирэмсэн аюултай шинжүүд Эхээс урагт дамжих халдварт /ХДХВ/ДОХ,</p> <p>Тэмбүү, гепатитын В вирус/</p> <p>3. Жирэмсний чихрийн шижкингийн тухай</p> <p>4. Аарцгийн ёроолын супрах тухай</p> <p>3. Ургийн хөдөлгөөнийг хянах, тоолох тухай</p>
	32 долоо хоног	<p>1. Жирэмсний явц, ургийн хөгжлийг хянанаа</p> <p>2. Жирэмсний амраалт олгоно (Солилцох худсиг олгоно)</p> <p>3. Эрүүл мэндийн боловсрол олтох булагийн сургалтыг зохион байгуулна</p> <p>4. Жирэмсний тэтгэмж авах эрх Уссэн иргэнд эмнэлгийн хуудсыг олгоно.</p> <p>*Эх эмэгтэйчүүдийн эмч узлэг хийж, зөвлөгөө өнөө</p>	<p>1. Зовуурь Сурьеэ илрүүлэх (Хавсралт 3)</p> <p>2. Ургийн хөдөлгөөн</p> <p>3. Хүчирхийллийг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p> <p>4. Төрөлжсөн эмэгтэйг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p>	<p>1. Ерөнхий биесийн Узлэг</p> <p>2. Амин үзүүлэлт</p> <p>3. Биесийн жин барихын гадуур Узлэг</p>	<p>1. Цусны шинжилгээ Шээсний шинжилгээ</p> <p>2. Шинжилгээ Утрас, уマイн хувууний нийтон турхцийн шинжилгээ (МАЗОК)</p> <p>3. Утрас, уマイн хувууний нийтон турхцийн шинжилгээ (МАЗОК)</p> <p>4. Хэт авиан шинжилгээ</p>	<p>Бүлгийн сургалт-3*** (Хавсралт 4)</p> <p>Зөвлөгөө:</p> <p>1. Жирэмсэн аюултай шинжүүд Эхээс урагт дамжих халдварт /ХДХВ/ДОХ,</p> <p>Тэмбүү, гепатитын В вирус/</p> <p>3. Жирэмсний чихрийн шижкингийн тухай</p> <p>4. Аарцгийн ёроолын супрах тухай</p> <p>3. Ургийн хөдөлгөөнийг хянах, тоолох тухай</p>
				<p>1. Зовуурь Ургийн хөдөлгөөн</p> <p>2. Хүчирхийллийг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p> <p>3. Төрөлжсөн эмэгтэйг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p>	<p>1. Ерөнхий биесийн Узлэг</p> <p>2. Амин үзүүлэлт</p> <p>3. Биесийн жин барихын гадуур Узлэг</p>	<p>Бүлгийн Стрептококкийн халдварт илрүүлэх шинжилгээ хийнэ</p> <p>1. Жирэмсэн аюултай шинжүүд Эхээс урагт дамжих халдварт /ХДХВ/ДОХ,</p> <p>Тэмбүү, гепатитын В вирус/</p> <p>3. Төрөлжсөн эмэгтэйг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p> <p>4. Төрөх</p>
	36 долоо хоног	<p>1. Жирэмсний явц, ургийн хөгжлийг хянанаа</p> <p>2. Төрөлжсөн эмэгтэйг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p>	<p>1. Зовуурь Ургийн хөдөлгөөн</p> <p>2. Хүчирхийллийг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p> <p>3. Төрөлжсөн эмэгтэйг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p>	<p>1. Ерөнхий биесийн Узлэг</p> <p>2. Амин үзүүлэлт</p> <p>3. Биесийн жин барихын гадуур Узлэг</p>	<p>1. Ерөнхий биесийн Узлэг</p> <p>2. Амин үзүүлэлт</p> <p>3. Биесийн жин барихын гадуур Узлэг</p>	<p>Бүлгийн Стрептококкийн халдварт илрүүлэх шинжилгээ хийнэ</p> <p>1. Жирэмсэн аюултай шинжүүд Эхээс урагт дамжих халдварт /ХДХВ/ДОХ,</p> <p>Тэмбүү, гепатитын В вирус/</p> <p>3. Төрөлжсөн эмэгтэйг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p> <p>4. Төрөх</p>
				<p>4. Төрөлжсөн эмэгтэйг илрүүлэх асуумж (Хавсралт 3)</p>	<p>5. Хөхний Узлэг</p> <p>6. Эх барихын гадуур Узлэг</p>	<p>5. Хөхний Узлэг</p> <p>6. Эх барихын гадуур Узлэг</p>

		Өндөр жиремсэн: Төрөлжсөн мэргэжлийн эмч нарын узлагт хамруулах, эх барих эмэгтэйчүүдийн хяналтад шилжүүлнэ.	гадуур үзлэг		
№7	38 долоо хоног	1. Төрөх бэлтгэлийг хийнэ 2. Төрөлтийн төлөвлөгөө боловсруулна 3. Ургийн үрьдчилсан жинг тодорхойлно	1. Зовуурь 2. Ургийн хөдөлгөөн	1. Ерөнхий биелүүлэг 2. Амин үзүүлэлт 3. Биелүүлэлт 4. Хөхний үзлэг 5. Эх барижын гадуур үзлэг	1. Төрөлжсөн мэргэжлийн эмч нарын узлагт хамруулах, эх барих эмэгтэйчүүдийн хяналтад шилжүүлнэ.
№8	39-40 долоо хоног	1. Төрөлтөнд бэлтгэгдсэн байдлыг үнэлнэ 2. Ургийн үрьдчилсан жинг тодорхойлно	1. Зовуурь 2. Ургийн хөдөлгөөн	1. Ерөнхий биелүүлэг 2. Амин үзүүлэлт 3. Биелүүлэлт 4. Хөхний үзлэг 5. Эх барижын гадуур үзлэг	1. Төрөлжсөн мэргэжлийн эмч нарын узлагт хамруулах, эх барих эмэгтэйчүүдийн хяналтад шилжүүлнэ.

*****Тайлбар:**

- Жиремсний хяналтад эрт ороогүй тохиолдолд тухайн тээлтийн хугацаанд нь анхны үзлэтийн үед заавал хийх шинжилгээг бүрэн хийнэ.
- Жиремсний 11-13+6 долоо хоногтойд Пренатал илрүүлгийн шинжилгээг заавал хийнэ.
- Жиремсний 12-16 долоо хоногтойд шээсэнд нян илрүүлэх шинжилгээг заавал хийнэ.
- Жиремсний 18-22 долоо хоногтойд Ургийн бүтцийн хэт авиан шинжилгээг заавал хийнэ.
- Жиремсний 41 долоо хоног хүрсэн бол эмнэлэгт хэвтүүлж, төрүүлэх арга хэмжээ авна.
- Булгийн сургалт: Жиремсний тээлтийн хугацаагаар ижил булгээр хуваарилж эмэгтэй, түүний хамтрагч, гэр бүлгийг оролцуулан эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг цахим болон танихмаар 3-аас доошгүй удаа зохион байгуулна.

Хүснэгт 2. Төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээ, хяналтын товтол

Үзлэгийн дугаар, товтол	Төрсний дараах үе	Үзлэгийн зорилго	Асуумж	Эхэд хийх үзлэг	Шинжилгээ	Зөвлөгөө, мэдээлэл
№1	Эхний 24 цагийн дотор (Төрсний дараа эмнэлэг доторх тусламж, үйлчилгээ)	1. Эх, нярайн биийн буйлыг 2. Хэвийн төрсэн бол 24 цаг эмнэлэгт хянах, гаргана 3. Амаржсан эмнэлгийн хуудсыг олгоно	1. Зовуурь 2. Гүнийн венийн буулэнт бөглөрлийн эрсдэлтийн үнэлгээ 3. Төрсний дараах эхийн сэтгэл гутралыг үнэлэх сорил (Хавсралт 3) 4. Эрт сэромжлүүлтийн үнэлгээ	1. Ерөнхий биийн үзлэг 2. Амин үзүүлэлтийг 6 цагаар хянах 3. Хөхний үзлэг хийх 4. Умайн агшилтыг 4 цагаар үзэх 5. Шавхарга үнэлэх (хэмжээ, өнгө, үнэр гм) 6. Шээсний ялгарлыг үнэлэх 7. Хяразанийн шархийг үнэлэх	1.Хэт авиан шинжилгээ 2. Цусны өрөнхий шинжилгээ (заалтаар) 3.Хөхний арчилгаа, эхийн сүүгээр дагнан хооллох 4.Зөв хөхүүлэх аргачлал 5.Аюулгүй бэлтийн харьцааны тухай 6.Цус багадалтаас үрьдчилан сэргийлэх (төмөр, фотийн хүчил) 7.Гэр бүл төлөвлөлт, ЖСАХ 8.Хамтрагч, гэр бүлийн оролцоо, дэмжлэг Нярайг асрах зөвлөгөө	Төрсний дараах эхэд өгөх зөвлөгөө 1.Төрсний дараах аюултай шинжүүд 2.Төрсний дараах физиологийн өөрчлөлт, авах арга хэмжээ 3.Хөхний арчилгаа, эхийн сүүгээр дагнан хооллох 4.Зөв хөхүүлэх аргачлал 5.Аюулгүй бэлтийн харьцааны тухай 6.Цус багадалтаас үрьдчилан сэргийлэх (төмөр, фотийн хүчил) 7.Гэр бүл төлөвлөлт, ЖСАХ 8.Хамтрагч, гэр бүлийн оролцоо, дэмжлэг 1.Нярайн аюултай шинж хийгдэх иргүүлэг шинжилгээ 3.Нярайн асаргаа; усанд оруулах арьс, хүйн арчилгаа, зөв байрлалд үнтуулах, бүтэн биеийн илтэг хийх 4.Дархлаажуулалт 5.Төрсний дараа эхийн 6 сар эхийн сүүгээр дагнан хооллох, түүний ач холбогдол 6.А болон Д аминдэм өгөх 7.Нярайн хөгжлийг үнэлэх, танин мэдэхүй сээтэхүйг хөгжүүлэх
№2	Төрсний дараах 48-72 цагт (Гэрийн эргэлт I)	Төрсний дараах эмгэг илрүүлнэ**	1. Зовуурь 2. Эрт сэромжлүүлтийн үнэлгээ	1. Ерөнхий биийн үзлэг 2. Амин үзүүлэлт 3. Умайн ашилтыг үнэлэх 4. Хяразанийн шархийг үнэлэх	1.Нярайн аюултай шинж хийгдэх иргүүлэг шинжилгээ 3.Нярайн асаргаа; усанд оруулах арьс, хүйн арчилгаа, зөв байрлалд үнтуулах, бүтэн биеийн илтэг хийх 4.Дархлаажуулалт 5.Төрсний дараа эхийн 6 сар эхийн сүүгээр дагнан хооллох, түүний ач холбогдол 6.А болон Д аминдэм өгөх 7.Нярайн хөгжлийг үнэлэх, танин мэдэхүй сээтэхүйг хөгжүүлэх	
№3	Төрсний дараах 7-14 хоногт (Гэрийн эргэлт II)	Төрсний дараах эмгэг илрүүлнэ**	1. Зовуурь 2. Төрсний дараах эхийн сэтгэл гутралыг үнэлэх сорил (Хавсралт 3)	1. Ерөнхий биийн үзлэг 2. Амин үзүүлэлт 3. Умайн ашилтыг үнэлэх	1. Ерөнхий биийн үзлэг 2. Амин үзүүлэлт	1. Ерөнхий биийн үзлэг 2. Амин үзүүлэлт
№4	Төрсий дараах 5-6 дахь долоо хоногт (Гэрийн эргэлт III)	Төрсний дараах эмгэг илрүүлнэ**	1. Зовуурь 2. Төрсний дараах эхийн сэтгэл гутралыг үнэлэх сорил (Хавсралт 3) 3. Хүчирхийлийг илрүүлэх асуулж (Хавсралт 3)			

**Тайлбар: Төрсний дараах эмгээг байдал илэрсэн тохиолдолд дараагийн шаталын эх барих, эмэгтэйчүүдийн эмчид эсхүл төрсөн эмнэлэгт илгээнэ.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
сарын 09-и өдрийн дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

**ЖИРЭМСЭН, ТӨРӨХ, ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН
ЭРСДЭЛИЙГ ИЛРҮҮЛЭХ АСУУМЖ**

Асуумж 1. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг илрүүлэх асуумж

Эрсдэлийн бүлэг	Нөлөөлөх хүчин зүйл	
A	Нийгэм биологийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none">19-өөс доош насны (өсвөр насны) жирэмсэн;30-аас дээш насны тулгар төрөгч;35-аас дээш насны жирэмсэн;Нэн ядуу жирэмсэн эмэгтэй;Хоол тэжээлийн дутагдалтай;Байнга тамхи татдаг, архи уудаг, мансууруулах бодис хэрэглэдэг (доогуур зур)Хүчирхийлэлд байдаг
B	Эх барихын ужиг дурьдатгал	<ul style="list-style-type: none">5 ба түүнээс олон төрсөн;Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед цус алдаж байсан;Жирэмсэн, төрөлтийг мэс засал, мэс ажилбараар төгссөнМанас таталтын урьдал, манас таталтаар хүндэрсэнҮжил халдвараар хүндэрсэн;Зурсан зулбалт, үр хөндөлт (2 ба түүнээс дээш удаа), дутуу төрөлт, умайн гаднах жирэмсэн, цулцант хураа, өсөлтгүй жирэмсэн;Ураг, нярай нь эндсэн;Удамшлын болон төрөлхийн хөгжлийн гажигтай хүүхэд төрүүлсэн;Эмэгтэйчүүдийн мэс ажилбар хийгдэж байсан, умайн хавдар авахуулсан, хярзанд мэс ажилбар хийгдсэн бусад;Үргүйдлийн өгуулэмжтэй
B	Эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none">Зүрх, судасны эмгэг: Артерийн даралт ихсэх өвчин, хэрлэг, төрөлхийн гажиг, бусадАмьсгалын замын эмгэг: Багтраа, хатгалгаа, бусадХоол боловсруулах замын эмгэг: Ходоодны шархлаа, элэгний архаг үрэвсэл, элэгний хатуурал, жирэмсэн үеийн цэс зогсонгошил, бусадБөөр, шээний замын эмгэг: Өрөөсөн бөөртэй, гидронефроз, нефрит, бөөрний хурц ба архаг дутагдал, бусадДотоод шүүрлийн булчирхайн эмгэг: Бамбайн эмгэг, чихрийн шижин, тураал, хоол тэжээлийн дутагдал, аминдэм эрдэс бодисын дутагдал, бусадЦусны өвчин: Жирэмсэн үеийн тромбоцитопени, цус багадалтын 2,3-р зэрэг, бусадХөхний болон эмэгтэйчүүдийн өвчин: Хөхний эмгэгүүд, дайвруудын үрэвсэл, умай умайн хүзүүний үрэвсэл, эндометриоз, бусад

		<ul style="list-style-type: none"> Халдварт өвчин: Сүрьеэ; ХДХВ/ДОХ, тэмбүү, заг хүйтэн, трихомониаз, хламид, элэгний үрэвсэл, бэлэг эрхтний хомхой, бусад Нүдний өвчин: холын харалган 2,3-р зэрэг, нүдний даралт ихсэлт, бусад Сэтгэцийн өвчин, Мэдрэлийн өвчин, Холбогч эдийн өвчин, Автоиммуны өвчин, Удамшлын өвчин, Хорт хавдар, Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийгдсэн, Резус сөрөг бүлгийн цустай, Таргалалт, Бусад
Г	Одоогийн жирэмсний явцад эмгэг байдал илэрсэн	<ul style="list-style-type: none"> Жирэмсний эрт үеийн хордлого (хүнд хэлбэр) Жирэмсэн үеийн цус алдалт Манас таталтын урьдал Ургийн буруу байрлал Ургийн удамшлын эмгэг, төрөлхийн хөгжлийн гажиг Олон урагт жирэмсэн Ихэс түрүүлэлт, хүйн эмгэг Үр шилжүүлэн суулгасан Ураг орчмын шингэний ихдэлт, багадалт Ургийн өсөлтийн saatал Ургийн бүтэлт

Тайлбар:

- Жирэмсний өндөр эрсдэлийг анх хяналтад ирэх үед, жирэмсний 20, 28, 36 долоо хоногтойд асуумж, үзлэг, шинжилгээг үндэслэн илрүүлж, тогтооно.
- Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэй бүрд тохирсон хяналтын товлол, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- А бүлгээс өсвөр насны жирэмсэнгээс бусад 1 хүчин зүйл илэрсэн бол өндөр эрсдэлтэй гэж тооцох боловч өрх, сумын эмч хянана. Харин өсвөр насны жирэмсэн эмэгтэйг эх барих, эмэгтэйчүүдийн эмч хянана.
- Эрсдэлийн Б, В, Г бүлгээс аль нэг хүчин зүйл илэрч байвал өндөр эрсдэлтэй жирэмсэн гэж үнэлэн эх барих, эмэгтэйчүүдийн эмч хянана.

Асуумж 2. Жирэмсэн эмэгтэйд сүрьеэ өвчин илрүүлэх асуумж

1. Жирэмсэн эмэгтэйг анх хяналтад ирэх үед, 20, 32 долоо хоногийн үзлэгийн үед дараах асуумж авна:

- Та өмнө нь сүрьеэгээр өвчилж байсан уу?
- Хамт амьдарч байсан хүмүүс нь сүрьеэгээр өвчилсөн хүн байсан юу?
- 14 хоногоос дээш хугацаагаар ханиалгаж байна уу?
- Шалтгаангүй халуурч байна уу?
- Биеийн жин буурч, турж байна уу?
- Ханиалгах үед цэр гарч байна уу?
- Шөнөдөө хөлрөх зовиур илэрч байна уу?
- Ядрах, сульдах, ажлын бүтээмж буурсан шинж илэрч байна уу?

2. Бүх асуултад ҮГҮЙ гэж хариулбал “Одоогоор сүрьеэгийн болзошгүй тохиолдол биш” гэж дүгнэнэ.

3. Нэг асуултад “ТИЙМ” гэж хариулбал “Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдол” гэж дүгнэж, мэргэжлийн эмчид илгээнэ.

4. Мэргэжлийн эмч жирэмсэн эмэгтэйг үзэж, оношилгоо, эмчилгээг шийдвэрлэнэ.

5. Сүрьеэ өвчин оношлогдсон жирэмсэн эмэгтэйг эх барих, эмэгтэйчүүдийн болон сүрьеэгийн эмч хамтран хянана.

6. Эмч нарын хамтарсан үзлэг, зөвлөгөөнөөр жирэмсний хугацаанаас хамаарч, тээх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

7. Халдвартай сүрьеэтэй эхээс төрсөн нярайг БЦЖ вакцинаар дархлаажуулахгүй, хучин төгөлдөр мөрдөгдөж буй сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зааврын холбогдох заалтыг мөрдөнө.

Асуумж 3. Жирэмсэн эмэгтэйд хүчирхийллийг илрүүлэх асуумж

Жирэмсэн эмэгтэйг анх хяналтад ирэх үед, 24, 36 долоо хоногийн үзлэгийн үед, мөн төрсний дараа 7-14 хоногт дараах асуумжийг авч, гэр бүлийн хүчирхийллийн болзошгүй эрсдэлийг илрүүлнэ.

1. Таны хамтрагч эсхүл дотны хэн нэгэн танд бие махбодийн болон сэтгэлзүйн хүчирхийлэл үйлдэж байсан уу?
ТИЙМ ҮГҮЙ
2. Сүүлийн нэг жилийн хугацаанд хэн нэгэн таныг цохих, алгадах эсхүл танд бие махбодийн гэмтэл учруулсан уу?
ТИЙМ ҮГҮЙ
Хэрэв ТИЙМ бол хэн бэ? (доогуур зур)
Нөхөр Хуучин нөхөр Найз залуу Хуучин найз залуу
Танихгүй хүн Бусад.....
3. Жирэмсэн болсноос хойш хэн нэгэн таныг цохих, алгадах эсхүл танд бие махбодийн гэмтэл учруулсан уу?
ТИЙМ ҮГҮЙ
Хэрэв ТИЙМ бол хэн бэ? (доогуур зур)
Нөхөр Хуучин нөхөр Найз залуу Хуучин найз залуу
Танихгүй хүн Бусад.....
4. Сүүлийн нэг жилд хэн нэгэн таныг бэлгийн харьцаанд орохыг хүчилж, шаардсан уу?
ТИЙМ ҮГҮЙ
Хэрэв ТИЙМ бол хэн бэ? (доогуур зур)
Нөхөр Хуучин нөхөр Найз залуу Хуучин найз залуу
Танихгүй хүн Бусад.....
5. Та хамтрагч, найз залуу, гэр бүлийн гишүүнээсээ айж эмээдэг үү?
ТИЙМ ҮГҮЙ

Тайлбар:

- ≥1 удаа ТИЙМ гэж хариулсан бол сорилын хариу зерэг буюу хүчирхийллийн эрсдэлтэй гэж дүгнэнэ.
- Сорилын хариу зерэг гарсан тохиолдлыг хороо, сумын нийгмийн ажилтанд мэдэгдэж, нарийвчилсан үнэлгээг хийн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эргэх холбоотой ажиллана.

Асуумж 4. Төрсний дараах сэтгэл гутралыг үнэлэх Эдинбургийн сорил

Овог нэр: Огноо: Төрсний дараах хэд дэх хоног:

Доорх асуултад сүүлийн 7 хоногийн байдлаар хариулна уу.

- | | | | | |
|--|----------------------------|---|--|---|
| 1. Би аливаа зүйлийн хөгжилтэй талыг харж, инээж чаддаг. | — Ургэлж чаддаг | 0 | — Угүй, би асуудлыг даван туулж чаддаг | 0 |
| | — Ихэнхдээ чаддаг | 1 | — Угүй, ихэнхдээ би асуудлыг давж чадна гэж боддог | 1 |
| | — Маш ховор | 2 | — Тийм, заримдаа би даван туулах чадваргүй юм шиг санагддаг | 2 |
| | — Огт угүй | 3 | — Ихэнхдээ даван туулах чадваргүй юм шиг санагддаг | 3 |
| 2. Би аливаа зүйлийн сайн тал, зэрэг байдлыг харж чаддаг. | — Ургэлж чаддаг | 0 | 7. Сүүлийн үед аз жаргалгүй байдлаас болж нойрондоо муудаж, унтахад бэрхшээлтэй байна. | |
| | — Урьд өмнөхөөсөө багассан | 1 | — Огт угүй | 0 |
| | — Маш ховор | 2 | — Заримдаа тийм | 1 |
| | — Бараг угүй | 3 | — Ихэнхдээ тийм | 2 |
| 3. Ямар нэгэн юм буруу болвол би өөрийгөө үндэслэлгүй буруутгадаг. | — Огт угүй | 0 | — Ургэлж тийм | 3 |
| | — Маш ховор | 1 | 8. Би гунигтай бас уйтгартай байна. | |
| | — Заримдаа | 2 | — Огт угүй | 0 |
| | — Ургэлж | 3 | — Заримдаа тийм | 1 |
| 4. Би тодорхой шалтгаангүйгээр санаа зовниж, сэтгэл түгшдэг. | — Огт угүй | 0 | — Ихэнхдээ тийм | 2 |
| | — Маш ховор | 1 | — Ургэлж тийм | 3 |
| | — Заримдаа | 2 | 9. Сүүлийн үед аз жаргалгүй байдлаас болж уйлдаг болсон. | |
| | — Ургэлж | 3 | — Огт угүй | 0 |
| 5. Би тодорхой шалтгаангүйгээр аиж, сандардаг. | — Огт угүй | 0 | — Заримдаа тийм | 1 |
| | — Маш ховор | 1 | — Ихэнхдээ тийм | 2 |
| | — Заримдаа | 2 | — Ургэлж тийм | 3 |
| | — Ургэлж | 3 | 10. Надад өөрөө өөрийгөө гэмтээх бодол төрдөг. | |
| 6. Надад бүх зүйл боломжгүй мэт хэцүү санагддаг. | — Огт угүй | 0 | — Огт угүй | 0 |
| | — Цөөн удаа | 1 | — Заримдаа | 1 |
| | — Заримдаа | 2 | — Нэлээд их | 2 |
| | — Нэлээд их | 3 | | |

Тайлбар:

1. Төрсний дараа эхний 7 хоногийн хугацаагаар асуултыг асууж үнэлнэ (яг өнөөдрийн байдлыг үнэлэхгүй).
2. Нийт оноо **≥11** бол төрсний дараах сэтгэл гутралтай гэж үнэлэн эх барих, эмэгтэйчүүдийн болон төрөлжсөн мэргэшлийн эмчид илгээж, зөвлөгөө авна.
3. Амшиг хорлох сэдэлгүй, эсвэл сорилын оноо 5-9-ийн хооронд байвал 1 сарын дараа сорилыг дахин үнэлэх шаардлагатай.

Эруул мэндийн сайдын 2024 оны
06. сарын 24. өдрийн дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

Жирэмсний бүлгийн сургалтын агуулга

Сургалтын ерөнхий сэдэв	Сургалтын агуулга
Бүлгийн сургалт-1 /Жирэмсний эхний 3 сар/	
Жирэмсний хяналтын товлолын талаар	<ul style="list-style-type: none"> Жирэмсний тээлтийн ямар хугацаанд эмнэлэгт үзүүлэх талаар жирэмсэн эмэгтэй, түүний гэр бүлд мэдээлнэ. Жирэмсэн үед хийгдэх зайлшгүй шинжилгээг хаана, яаж хийлгэх талаар мэдээлнэ.
Хооллолт, дасгал хөдөлгөөний талаар	<ul style="list-style-type: none"> Жирэмсэн эмэгтэйн зохистой хооллолтыг дэмжих, дасгал хөдөлгөөний зөвлөгөөг өгч жирэмсний хугацаанд жин ихээр нэмэхээс сэргийлнэ. Жирэмсэн үед хэрэглэхэд тохиромжтой ба татгалзах хүнс, хүнсний бүтээгдэхүүний талаар мэдээллийг өгнө. Архи, тамхи, мансууруулах бодисноос татгалзах, эх, урагт үзүүлэх хор уршгийн талаар мэдээллийг өгнө. Каффейны хэрэглээг хязгаарлах талаар мэдээллийг өгнө.
Амин дэм, эрдэсийн хэрэглээний талаар	<ul style="list-style-type: none"> Төмрийн бэлдмэлийг хоногт 30-60 мг-аар, фолийн хүчлийг 400 мкг (0.4 мг)-аар хэрэглэснээр жирэмсэн үеийн цус багадалт, үжил, бага жинтэй нярай төрөх, дутуу төрөлтөөс сэргийлнэ. Кальцийн бэлдмэлийг ууж хэрэглэснээр манас таталтын урьдлын эрсдэлээс сэргийлнэ. Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн талаар мэдээллийг өгнө.
Бүлгийн сургалт 2 /Жирэмсний хоёр дахь 3 сар/	
Жирэмсэн үед тохилдох зарим эмгэгийн талаар	<ul style="list-style-type: none"> Жирэмсэн үеийн цус багадалт Шинж тэмдэггүй бактерури Жирэмсний чихрийн шижин Манас таталтын урьдал
Жирэмсэн үед илрэх зарим шинж тэмдэг, авах арга хэмжээний талаар	<ul style="list-style-type: none"> Өтгөн хатах, гэдэс дүүрэх Арьс язрах, нөсөөжих Хавагнах Шээс задгайрах Ангир уураг гарах, хөхний толгой бэлдэх
Бүлгийн сургалт 3 /Жирэмсний гурав дахь 3 сар/	
Ургийн хөдөлгөөнийг өөрөө тоолох	<ul style="list-style-type: none"> Эх өөрөө ургийн хөдөлгөөнийг 10 хүртэл тоолж тэмдэглэх
Төрөлтийн тухай	<ul style="list-style-type: none"> Төрөх үеийн хувийн бэлтгэл Төрөлт эхэлсэн шинж Төрөх үеийн туслагч

	<ul style="list-style-type: none"> Хярзангийн массаж Нярайг эрт амлуулах, арьс арьсаар шүргэлцүүлэх талаар
Төрсний дараах үеийн тухай	<ul style="list-style-type: none"> Умайн агшилт, шавхарга Аарцагын ёроолын булчин сулрах, шээс задгайрах Хярзангийн оёдол арчилах Нярайн асаргаа, сувилгаа Гэр бүл төлөвлөлт
Хөхөөр хооллох тухай	<ul style="list-style-type: none"> Хөхний арчилгаа Эхийн сүүний найрлага, ач холбогдол Эхийн сүүгээр дагнан хооллох тухай Хүүхдээ хэзээ хөхүүлэх талаар Зөв хөхүүлэх аргачлал

Тайлбар:

- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн их эмч, эх баригч, нийгмийн ажилтан нар бусад нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдтэй хамтран харьяалах нутаг дэвсгэрийн бүх жирэмсэн эмэгтэйчүүдийг оролцуулан 3-аас багагүй удаа жирэмсний бүлгийн сургалтыг зохион байгуулна.
 - Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүд нь тухайн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн сургалтад заавал хамрагдахаас гадна хянагдаж буй эрүүл мэндийн байгууллагаас оношийн бүлгийн дагуу зохион байгуулж буй сургалтад оролцно.
- Танхимын сургалтыг жирэмсний тээлтийн хугацаа ижил, 15 хүртэлх эмэгтэйчүүдийг нэг бүлэгт хуваарилан ар гэрээс нэг гишүүнийг оролцуулж зохион байгуулна.
 - Бүлгийн сургалтыг агааржуулалт сайтай, тохижилттой том өрөө танхимд зохион байгуулах ба өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд сургалтын орчин бүрдэх боломжгүй бол нийгмийн эрүүл мэндийн эсхүл боловсролын болон бусад сайн дурын байгууллагатай хамтран зохион байгуулна.
- Цахим сургалтыг төрийн эсхүл хувийн хэвшлийн өмчийн программ хангамж, платформуудаар дамжуулан зохион байгуулна.
 - Тухайн жирэмсний тээлтийн хугацаанд тохирсон, нотолгоонд суурилсан зөвлөгөө, мэдээллийн контентыг жирэмсэн эмэгтэйн цахим хаягруу эсхүл бусад хэлбэрээр илгээнэ.
 - Цахим сургалтад хамрагдсан талаар асуумжыг иргэн бөглөснөөр сургалтын үр дүнг үнэлнэ.
- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч нь эрүүл мэндийн цахим системээр иргэний И-Монгол (E-Mongolia) системрүү эсхүл хувийн гар утсаар сургалтын зарыг түгээнэ.